



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар

А/321

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Буянт сумын Норжинхайрхан багт гүн өрмийн худгийн барилгын засвар хийж, ухаалаг тоног төхөөрөмж суурьлуулсан ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналт хариуцсан мэргэжилтэн

Б.Түвшинсайхан - Буянт сумын Засаг дарга

Ч.Идэрсайхан - Буянт сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн

дарга: Э.Гансүх


- Хүнс, хөдөө аж ахуйн газрын

Бэлчээр, усан хангамж хариуцсан мэргэжилтэн

2. Гүн өрмийн худгийн барилгын засвар, ухаалаг тоног төхөөрөмж суурьлуулсан ажлыг хүлээн авахдаа холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Тухайн ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

8400 01 1637
Zah A/321 Kh